



Оройн Дээд Цагаан Лянхуа судар
"Оршил" хэмээх нэгдүгээр бүлэг


The World of the Lotus Sutra

Шагжамуни бурхан "Билэг утга төгөлдөр судар"-ыг айлдаж дуусаад гүн бясалгал самадид оров. Тэгтэл тэнгэр, газар ихэд байсаад цэцэгсээр хур оруулж, газар долгисон хөдлөв. Тэнгэр газар долгисон баясахыг харсан хамаг амьтад машид цэнгэн баясаад Шагжамуни буддад алгаа хамтатган хүлээн суув. Тэгтэл Шагжамуни бурханы хөмсгийн завсрын сангийн цагаан үснээс гэрэл цацарч олон гариг, ертөнцийг гийгүүлэн харуулав. Ямар ч гариг, ертөнцийг харсан бай хамаг амьтад зовж, шаналан, төөрөлдөж байгаа дүр зураг харагдав. Түүнчлэн ямар шалтгаанаар тийм үр дүнд хүрсэн болох нь ч харагдав. Бас хаашаа ч харсан бай бурхад байх бөгөөд хүмүүс бурханы сургаалийг сонсож, хэрэгжүүлэхийн тухайд шамдаж байв. Их, бага олон бодисадва байх бөгөөд тэдгээр бүгд бодисадвагийн үйлд шамдаж байлаа.

Энэ их билэгсийг хараад ихэд гайхсан Майдар бодисадва түүний учирьг асуухаар завдсан ч Шагжамуни будда самадид орсон байсан тул чадсангүй. Гэвч тэрхэн зуур Манзушири бодисадваг олж хараад «Манзушири бодисадва тэргүүлшгүй цагаас тоолшгүй олон бурхадыг өргөн хүндэлж, суралцсан болохоор энэ их билэгсийн учрыг мэдэж байх учиртай» хэмээн бодов. Бас эргэн тойрных нь хүмүүс бурхан багш энэ их утгасыг юуны учир үзүүлэв гэдгийг

хэнээс асуух вэ хэмээн эргэлзэж байгааг илтэд мэдээд Манзушири бодисадвагаас учирьг асуув.

Манзушири бодисадва ингэж хариулав. «Шагжамуни бурхан одоо сургааль бүхний орой болсон дээдийн номоо айлдах гэж байгаа нь гарцаагүй. Эрт нэгэн цагт Түүнчлэн Ирсэн Наран Саран зул хэмээх бурхан ертөнцөд мэндэлсэн юм. Тэрээр хутагтын дөрвөн үнэн, зургаан билэг брамида, 12 учир шалтгааны сургаалийг айлдав. Түүний дараагаар мөн л Түүнчлэн ирсэн наран саран зул нэртэй хоёр зуун мянган бурхан ертөнцөд мэндэлж адилхан сургааль айлдаад самадид ороход хөмсөг завсрын сангийн цагаан үснээс нь гэрэл гарч гариг, ертөнцийг гэрэлтүүлж байсан. Улмаар самадигаас босоод айлдсан сургааль нь Оройн Дээд Цагаан Лянхуа судар юм. Тиймээс Шагжамуни бурхан одоо Оройн Дээд Цагаан Лянхуй судрыг айлдах гэж байгаа нь гарцаагүй. Тийм болохоор алгаа хамтатган, бишрэлийг үүсгээд, нэгэн сэтгэлээр хүлээн суугтун. Бурхан багш гайхамшигт сургаалиа айлдаж гэгээрлийг олохыг хүсэх хүмүүний хүслийг гүйцээх бус уу» хэмээв.



Special Topics

Бангладешийн залуу гишүүдийн их хурал боллоо

Өнгөрсөн сарын дөрвөнд Бангладешын Кокс Базар дүүргийн цэнгэлдэх хүрээлэнд Кошё багшийн удирдлагаар Бангладешийн залуу гишүүдийн сургалт, семинар болж өнгөрлөө. Бангладешийн өнцөг, булан бүрээс 144 автобусаар ирсэн залуу гишүүдийн тоо 13 мянгад хүрсэн юс. Бүхэл бүтэн 20 цаг зарцуулж автобусаар ирсэн гишүүд ч цөөнгүй байлаа.

Кошё багш «Хүн тус бүр бурханлаг чанартай оршихуй гэдгээ анзаарах нь чухал. Хүний язгуурын мөн чанар бол харилцан нэгнээ түшиж, дэмжин хөгжүүлэх явдал юм» гэж хэлээд Бодисадвагийн үйлийг хэрэгжүүлэх ач тусын тухай заасан юм. Хуралд Бангладешийн Дотоод хэргийн яамны сайд болон УИХ-ын гишүүдээс ирж

оролцов. Хурлын арга хэмжээ тус дүүргийн телевиз, радио, сонин хэвлэлээр цацагдсан юм.

Бангладешийн 13 мянган залуу гишүүн цугларсан цэнгэлдэх хүрээлэн «Цагаан Лянхуа Судрын Газрын доороос гарсан Бодисадва нар хэмээх 15-р бүлэг»-ийн үзэгдэл шиг л харагдаж байлаа.



Амьдралын талбар бол нийгэмлэг

Рисшо Косей-Кайгийн ерөнхийлөгч
Нивано Ничико

Сургаалийг хэрэгжүүлэх нь

Сургаальд суралцаж, сурсанаа өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх—энхүү сүсэг бишрэлтэй амьдралын аливаа дүр төрх бол Үүсгэн Байгуулагчийн заавар төдийгүй Косей Кайгийн онцлог юм.

Судрын эхэнд уншдаг “Бясалгал үйлдэн гэгээрэх замууд” хэмээх оршил шүлэгээр дамжуулж бурхан багшийн үзэл, суртгаалаас бататган суралцъяа гэж бодлоо.

Та бүгдийн мэдэж байгаа шиг “Оршил шүлэг”-г «Эдгээрийг сүсэгтэн олон мэдэгтүн. Энэ газар нь номын ордон болой. Бурхад энд заларч аннутгара-самьяк-самбодыг олж эзэлсэн. Бурхад энд заларч номын хүрдийг эргүүлсэн. Бурхад энд заларч пара нирваанд хувилсан” гэж байдаг.

Номын ордон гэдэг нь Шагжамуни бурхан гэгээрлийг олсон боди модыг хэлдэг боловч дээр өгүүлсэн «Энэ газар нь номын ордон болой» хэмээх шад өгүүлбэр нь илүү өргөн утгатай юм.

«Бидний байгаа газар нь бурхад гэгээрлийг олж, сургаалиа айлдаад, нирвааны хутагт орсон газар» гэсэн утгатай юм. Буддистууд бидний хувьд бүхэл амьдралынхаа турш сургаальд суралцаж, түүнийг хэрэгжүүлэх газар бүхэн “Номын ордон” юм.

Бид бурхан, шүтээнийхээ өмнө суугаад судар унших үед «Өдөр тутмын амьдралдаа сургаалийг хэрэгжүүлнэ» хэмээн тангараглаж байдаг.

Гэвч бидний тэр сэтгэл өдөр бүрийн амьдралд тохиолдох ямар нэг зүйлд сатааран, назгайрч орхидог. Тиймээс оршил шүлгийг урин уншиж сэтгэлээ дахин нэг бататгаж чадах бус уу.



Хятадын гүн ухаантан Ооёомэй «Мэднэ гэдэг үйлдэхийн эхлэл бөгөөд үйлдэж байж бүрэн төгс ойлгоно» гэж хэлсэн байдаг.

Гэгээрлийн замаар замнана гэдэг маань үүнтэй яг алилхан. Хэрэгжүүлж байж л сургаалийг амилуулж чадна. Тэр утгаараа сургаалийг хэрэгжүүлж байгаа газар бүхэн номын ордон юм.

Нийгэмлэг дээрээ Хутагтын найман мөр, зургаан билэг барамид, зэрэг сургаальд суралцан, тэдгээрийг өдөр тутмын амьдрал даа хэрэгжүүлэх нь чухал юм. Нэмж хэлэхэд гэр бүл, сургууль, ажил, автобус, дэлгүүр, гуанз ч гэсэн сургаалийг хэрэгжүүлэх номын ордон болдог.

Гэхдээ тэнд хамгийн чухал нь «Одоо энд» гэсэн сэтгэл юм.

Шагжамүни бурхан хүний амьдралыг “Ганц хором” хэмээн сургасан байдаг. Тийм болохоор агшин, хором тутамд хамаг чадлаараа амьдрах нь сургаалийг хэрэгжүүлж байгаа явдал юм. Ямар нэг онцгой үед л хамаг чадлаараа хичээх бус ямагт юм бүхэнд чин сэтгэлээсээ хандаж хичээх нь чухал юм.

Гэнэтийн асуудал үүссэн ч «Одоо энд» гэсэн сэтгэлээр хандаж, хамаг хүчээ дайчилж чадвал асуудлыг шийдэх зам нээгдэж ирдэг. Яагаад гэвэл «Одоо» хэмээх богинохон цаг хугацааны хэлхээ нь ирээдүй учираас.

Сургаалийг хэрэгжүүлэх газар нь гагцхүү нийгэмлэг биш юм. “Юима” хэмээх сударт «Нисваанис, энэ нь номын ордон болой» гэж

бичсэн байдаг. Бодийн сэтгэл, нисваанис хоёр нь нэг зүйлийн хоёр тал юм. Өөрөөр хэлбэл нэг зүйлийн хоёр тал болохоор салгах арга байхгүй гэсэн утгыг илэрхийлдэг. Түүн шиг төөрөгдөл байгаа болохоор гэгээрлийг олж чадна. Төөрөгдлийн учир шалтгааны эрж хайн түүний үндэс, суурийг анзаарч чадвал гэгээрлийн ертөнц нээгддэг. Нэг үгээр хэлбэл гэгээрэл, төөрөгдөл хоёр нь эцсийн эцэст нэг зүйл гэсэн үзэл, санаа юм.

Хүн нисваанисын түйтгэрээр хүний төрлийг авдаг боловч гэгээрэлд хүрэх замаар замнаж чадна.

Үүн шиг аль ч цаг үе, ямар ч газар, ямар ч зүйл байсан тэдгээр нь бүгд, бидний сэтгэлийг боловсруулах номын ордон болдог юм. Үүнийг ухаарвал «Одоо энд» гэсэн сэтгэлээ марталгүй ямагт сургаалийг амьдралдаа хэрэгжүүлж чадна. Энэ үйлийг амьдралынхаа түшиг, тулгуур болгоод хамтдаа гэгээрлийн замаар замнацгаая.

Судар хурах тоолондоо урин дууддаг «Бясалгал үйлдэн гэгээрэх замууд» хэмээх оршил шүлэгийг «Одоо өөрийнхөө байгаа газар хамаг хүчээрээ хичээгээрэй» хэмээн бурхан багш бидэнд хандаж хэлсэн, нигүүлсэхүйн дуу хоолой гэж хэлж болох юм.

“Косэй” 2011 оны 3 сарын дугаараас



Дэлхийн энх тайван гэсэн агуу мөрөөдлийн төлөө

Солонгосын РКК
Ким Пён Ок

Би Сөүл хотоос метрогоор 3 цаг орчим явж хүрдэг Чёнан хотод амьдардаг. 10 жилийн өмнө РКК-д гишүүнээр элссэн. Тэр үед тэргүүн надад “Чёнанд ч гэсэн сургаалийн цэцгийг дэлгэрүүлээрэй” гэж хэлэхэд нь би юу ч мэдэхгүй хэрнээ «За» гэж их л чанга дуугаар хэлснээ санадаг юм.

Түүнээс хойш 10 жил өнгөрчээ. Ганц нэгээр хүмүүсийг сургаалийн замд хөтөлж, өдгөө долоо хоног бүрийн лхагва гаригт хоза хийж, хамтдаа Цагаан Лянхуа Сударт суралцаж байна.

Энэ жилийн хүйтний даяанд (Тэсгим хүйтэнд, хүйтэн усаар биеээ 108 удаа булхаж, хоёр долоо хоногт, «3 эрдэний судар»-ын 32 бүлгийг, уншиж дуусгадаг даяан) Чёнанд амьдардаг гишүүдийн хамт оролцсон юм. Хүйтний даяанд эхнээс нь дуустал оролцож чадсан баяр хөөрийг амтлангаа өөрсдийн далдын хүчинд итгэж чадсан юм. Түүнчлэн «Чёнанд ч гэсэн РКК-г байгуулахсан» гэсэн мөрөөдөлдөө нэг алхам ч болов ойртсон мэт санагдав.

Би 30 настайдаа янз бүрийн шалтгаанаас болж лам болсон юм. Гэвч өөрийн хүчээр зовж, шаналсан хүмүүсийг аз жаргалтай болгож чадахгүйдээ дотроо өөрөө өөртэйгээ зөрчилдөж эхлэв. Тэгж явахдаа РКК-тай учирсан юм.

«Юмс үзэгдэл, ямар нэг зүйлийн харилцаа холбооноос үүдэж өөрчлөгддөг» гэсэн үг надад итгэл найдвар төрүүлсэн юм. Түүнээс хойш би шалтгаан, нөхцөлийг хэрхэн холбох талаар толгойгоо гашилтал боддог боллоо. «Өөрөө өөрчлөгдвөл харилцагч өөрчлөгдөнө» гэдэг нь хэнч ойлгох энгийн хууль боловч дан ганц өөрийн хүчээр болгох зүйл биш юм.

Улмаар мичибикдсэн хүнээ өөрийнхөө толинд туссан тусгал хэмээн санаж, даяан хийдэг болов. Гэвч шүнийний үүрэг хүлээж авсанаасаа хойш харилцагчынхаа зовлонг ямар нэг аргаар шийдвэрлэхгүй бол болохгүй хэмээн гарах үр дүнд сэтгэл баригддаг байлаа. Тэр үед «Үр дүнг бурхан гаргадаг. Таны үүрэг бол харилцагчынхаа зовлон, жаргалыг хамтдаа мэдэрч, нигүүлсэхүйн сэтгэлээр ойртож дотносох явдал» хэмээн заалгуулаад аврагдав.

1.судар хурах, 2. мичибики, тэдори, 3.сургаальд суралцах гэсэн РКК-ын сүсгийн үндсэн гурван үйлэнд дахин, дахин давтан суралцсаар туйлын үнэний сургаалийг жаахан ч гэсэн ойлгодог боллоо. Одоо ирээдүйдээ хандаж санаа зовдоггүй болсон бөгөөд өдөр бүрийг амгалан, тайван өнгөрөөд болсон. Миний эргэн тойронд бурханы оршихуйг мэддэггүй, зөв сургаальтай учираагүй, зовлонд баригдсан хүмүүс олон бий. Үүсгэн байгуулагчын шавь болсныхоо хувьд олон хүнийг сургаальтай холбож, аз жаргалтай болгохын төлөө амь, биеээ хайрлахгүй зүтгэнэ ээ. «Дэлхийн энх тайван» гэсэн том зорилгыг өвөрлүүлсэн Үүсгэн байгуулагчдаа сэтгэлийнхээ гүнээс талархаж байна. Бидний нэг сэтгэл дэлхийд түгэн дэлгэрэхийн тухайтад өөртөө итгэлтэйгээр Үүсгэн байгуулагчийн сургаалийг түгээн дэлгэрүүлээд явъяа. Баярлалаа.

Баярлалаа



Shanzai welcomes your religious experience. Why don't you share your religious experience through Shanzai with members all over the world? Please send the script or inquiry to the email address; shanzai.rk-international@kosei-kai.or.jp@kosei-kai.or.jp. Thank you.

shanzai

Нүдэнд үл харагдах учрал

Бидний «би» гэж боддог бие мах бодь нь бусдын хийсэн янз бүрийн зүйлсийн тусламжтай оршдог. Зөвхөн бие мах бодь ч биш сэтгэл ч гэсэн адилхан юм. Олон хүнтэй учирч, харилцан нэгнээсээ суралцсан үзэл, бодол, туршлага нь сэтгэлийг бүтээж байдаг.

Биднийг бүтээж байдаг учирал, нөхцөл, болзол нь бидний төсөөлснөөс ч хол давсан гайхалтай үр дүнд хүргэдэг. Дан ганц бид ч биш энэ орчлонд орших бүх зүйл тэрхүү нөхцөл, болзолууд үүсч, хувисан өөрчлөгддөг бөгөөд үүнийг Шагжамуни бурхан «Шалтгаан нөхцөл» -ийн сургаалиар айлдаж энэ л хамгийн чухал гэж сургасан байдаг.

Энэхүү шалтгаан, нөхцөл нь нүдэнд харагдах олс мэт зүйлээр холбогдсон байдаг гэж хэлж болох зүйл биш юм. Тиймээс бид бүх зүйл шалтгаан, нөхцөлөөр барилдан оршиж байдгийг анзаарч чаддаггүй. Тиймээс л нүдэнд харагдах зүйл, мөнгөнд итгэж, түүнийг л хамгийн чухал мэтээр сэтгэж, чангаас чанга зуурсан байдаг. Гэвч шалтгаан, нөхцөлийн барилдагыг харж чадвал учирсан бүх зүйлдээ сэтгэлийн угаас талархаж, хүндэлж амьдардаг болно. Тэр талархлын сэтгэл нь л аз жаргалын үндэс юм.

Үүсгэн Байгуулагчийн Үг 5 P.154-155

C O L U M N

Гишүүний үнэмлэх барьсан залуус Кокс Базар дүүргийн хөл бөмбөгийн талбайн орох хаалганд тулж ирэв.Тэдний тоо 13 мянгад хүрч тоологдов. Бангладешийн түүхэнд ийм олон залуус нэг дор цугларсан нь анх удаа ажээ. Бангладешийн засгийн газар ч энхүү цуглааныг анхаарахгүй өнгөрч чадаагүй биз ээ.

Цуглаанд зочноор оролцож, үг хэлсэн Дотоод Явдлын Яамны сайд Чоүдүри Үүсгэн байгуулагч, Мёоко багш хоёрын нэрийг дурьдаад, шашин хоорондын хамтын үйл ажиллагааг эхлүүлсэн Косей Кайгийн дэлхийн энх тайванд хандсан гавьяа зүтгэлийг өндрөөр үнэлсэн юм.


Мөн боловсрол, хүмүүжилтэй залуус олноор төрөн гарах нь Бангладешийн ирээдүйд тустай болохыг цохон тэмдэглээд манай үйл ажиллагааг дэмжиж байгаагаа илэрхийлсэн юм.

Төлөвлөж байсан цагаас нэлээд хэтэрсэн боловч Чоүдүри сайд Кошё багшийн лекцийг дуустал нь сонсож, санал бодлоо хуваалцсан юм. Тэр хоёр анх удаа уулзаж байгаа ч эртний андууд мэт дотно ярилцаж харгадсан. Чоүдүри сайд Кошё багшид «Эдгээр залуусын ирээдүйг танд даатгалаа шүү» хэмээн итгэл хүлээлгэсэн юм.

(Kotaro Suzuki)

Рисшо Косей Кайгийн тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Нивано Никкё болон Наганүма Мёко нарын санаачилгаар үүсэн байгуулагдсан юм. Манай байгууллага нь “Лянхуа цэцгийн гурван судар”-ыг номлолынхоо эх үүсвэр болгож, гэр бүлээрээ шүтэх шашины нэгэн шинэ хэлбэр бөгөөд сургаалийг амьдрал ахуй, нийгэмд хэрэгжүүлж аз жаргалтай амьдрал, гэгээтэй нийгэм, дэлхийн энх тайваныг зорьдог юм.



Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2011

Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,
CA 92612, U.S.A.
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432
e-mail: info@buddhistcenter-rkina.org http://www.buddhistcenter-rkina.org

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA
Tel: (727) 560-2927
e-mail: rktampabay@yahoo.com
http://www.rkina.org/tampabay

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@mail.rkhawaii.org http://www.rkhawaii.org

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rk-la.com

Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: bonnerstyle@sbcglobal.net

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Denver

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-5569
e-mail: rkksf@sbcglobal.net

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattle@juno.com

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of Vancouver

Lotus Buddhist Circle

851 N San Mateo Dr, San Mateo, CA 94401, U.S.A.

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: koseiny@aol.com

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
Tel & Fax: 1-847-394-0809
e-mail: murakami3370@hotmail.com

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: ok.risshokoseikai@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls

724 Main St. Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.
Tel: 1-541-810-8127

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

4340 E Kentucky Ave #345 Glendale CO 80234, U.S.A.
Tel: 1-303-319-2765 Fax: 1-720-876-4534

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304
e-mail: hiromi_mat@yahoo.com http://www.rkk.org.br

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
Tel: 55-11-4724-8862

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District, Taipei City 100
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

Rissho Kosei-kai of Jilong

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

No. 4, Lane 60, Minquan Road, Pingtung City,
Pingtung County 900
Tel: 886-8-732-1241 Fax: 886-8-733-8037

Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,
Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Korean Rissho Kosei-kai of Masan

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,
Hong Kong, Special Administrative Region of the People's Republic
of China
Tel: 852-2-369-1836 Fax: 852-2-368-3730

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,
Ulaanbaatar, Mongolia
Tel & Fax: 976-11-318667
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sukhbaatar

18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar, Mongolia

Rissho Kosei-kai of Sakhalin

1-72 Amyrskaya Street, Yuzhno-Sakhalinsk
693000, the Russian Federation
Tel & Fax: 7-4242-43-78-56

Rissho Kosei-kai (Geneva)

1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland
Tel: 41-22-791-6261 *Fax:* 41-22-710-2053
e-mail: rkkgva@wcc-coe.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia**

Castello-2229 30122-Venezia Ve Italy
Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)

Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France
Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)

Rissho Kosei-kai of Sydney**Rissho Kosei-kai of Singapore****International Buddhist Congregation (IBC)**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibt-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-2850238

Rissho Kosei-kai of Dhaka

House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,
Dahka Cand.-1206, Bangladesh
Tel: 880-2-8316887

Rissho Kosei-kai of Mayani

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Sri Lanka

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka
Tel: 94-11-2826367 *Fax:* 94-11-4205632

Rissho Kosei-kai of Polonnaruwa

No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,
Sri Lanka

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Galle

"Suwisal" Bataganwila, Imaduwa, Sri Lanka

Rissho Kosei-kai of Kandy-wattegama

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

Branches under the South Asia Division**Delhi Dharma Center**

B-117 (Basement Floors), Kalkaji,
New Delhi-110019, India
Tel: 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713
e-mail: sakusena@hotmail.com

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
KOLKATA 700094, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal
Tel: 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832
e-mail: nrkk@wlink.com.np

Rissho Kosei-kai of Lumbini

Shantiban, Lumbini, Nepal

Other Groups**Rissho Kosei-kai Friends in Shanghai**

114, Nanshi Si Road, Zenruzhen, Putuo-qu, Shanghai, China